



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/22

Мөрөн

□ Үнэлгээний хороо байгуулах тухай □

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэцэрлэг сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус сумын сургуульд улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 71,726,600 (Далан нэгэн сая долоон зуун хорин зургаан мянга зургаан зуун) төгрөгийн төсөвт өртөгтэй хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 33,226,400 (Гучин гурван сая хоёр зуун хорин зургаан мянга дөрвөн зуун) төгрөгийн төсөвт өртөгтэй үдийн цай нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цэцэрлэг сумын сургуулийн захирал (Х.Төрмөнх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 15 -ны өдрийн А/22 дугаар
захирамжийн 01 дүгээр хавсралт



ЦЭЦЭРЛЭГ СУМЫН СУРГУУЛЬД ХҮҮХДИЙН ХООЛ,
ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО
(Төсөвт өртөг-71,726,600 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: Н. Ганжуур-Цэцэрлэг сумын Засаг даргын орлогч

Ч.Эрдэнэчимэг-"Ойн цэцэрлэг" ХХК-ийн захирал

О.Алтантариа-Аймгийн Хот тохижуулах үйлчилгээний төвийн бичиг хэргийн
ажилтан

Нарийн бичгийн дарга: Ч.Лхагвамядаг-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
Өмчийн хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 15-ны өдрийн А/22 дугаар
захирамжийн 02 дугаар хавсралт



ЦЭЦЭРЛЭГ СУМЫН СУРГУУЛЬД ҮДИЙН ЦАЙ
НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО
(Төсөвт өртөг-33,226,400 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Н. Ганжуур-Цэцэрлэг сумын Засаг даргын орлогч

Ч.Эрдэнэчимэг-"Ойн цэцэрлэг" ХХК-ийн захирал

О.Алтантэриг-Аймгийн Хот тохижуулах үйлчилгээний төвийн бичиг хэргийн ажилтан

Нарийн бичгийн дарга: Ч.Лхагвамядаг-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн мэргэжилтэн